



ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗРЫН ХАРЬЯА

**ОРХОН АЙМГИЙН
АУДИТЫН ГАЗАР**

61000 Орхон аймаг,
Баян-Өндөр сум Хүрэнбулаг баг
УБД 2070001050, Утас, Факс: 70359826
E-mail: orkhon@audit.gov.mn

2017.01.04 № 02

танай -ны № -т

Сумдын иргэдийн Төлөөлөгчдийн
хурлын 2016 оны ээлжит сонгуулийн
зардал, хандивын талаарх мэдээлэл

Орхон аймгийн сумдын иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2016 оны ээлжит сонгуульд оролцсон нам, нэр дэвшигчдийн сонгуулийн зардлын тайланг Сонгуулийн тухай хуулийн 60 дугаар зүйлийн 60.1-т заасны дагуу сумдын сонгуулийн хорооноос хүлээн авч хянаж, сонгуулийн зардлын дүн болон нэг сая ба түүнээс дээш төгрөгийн хандив өгсөн иргэн, хоёр сая ба түүнээс дээш төгрөгийн хандив өгсөн хуулийн этгээдийг Сонгуулийн тухай хуулийн 60 дугаар зүйлийн 60.3-т заасны дагуу мэдээлж байна.

Орхон аймгийн ИТХ-ын 2016 оны сонгуульд 2 сумын 52 тойрогт 52 мандатаар нэр дэвшигчдийг бүртгэж, сумдын сонгуулийн хороодын тогтоолуудаар 122 нэр дэвшигчдийн нэрсийг баталсан байна. Үүнд:

- МАН 2 сумын 51 тойрогт 51 нэр дэвшигч
- АН 2 сумын 52 тойрогт 52 нэр дэвшигч
- МАХН 2 сумын 12 тойрогт 12 нэр дэвшигч
- 2 сумын 7 тойрогт 7 бие даан нэр дэвшигч

Сонгуулийн тухай хуулийн 59 дүгээр зүйлийн 59.1-т "Энэ хуульд өөрөөр заагаагүй бол орон нутгийн сонгуульд нэр дэвшигч нь санал хураалт явагдсан өдрөөс хойш 30 хоногт багтаан сонгуулийн зардлын тайлан гаргаж тухайн шатны сонгуулийн байгууллагад хүргүүлэх үүрэгтэй" гэж заасны дагуу Орхон аймгийн Сонгуулийн хороонд дараах нэр дэвшигч нар хугацаандаа хүргүүлсэн байна. Үүнд:

- МАН-аас нэр дэвшсэн 51 нэр дэвшигч
- АН-аас нэр дэвшсэн 42 нэр дэвшигч
- МАХН-аас нэр дэвшсэн 3 нэр дэвшигч тайлангаа өгчээ.

Сонгуулийн тухай хуулийн 59.1 дэх заалтыг зөрчиж 26 нэр дэвшигч сонгуулийн зардлын тайлангаа аймгийн сонгуулийн хороонд ирүүлээгүй байна. Үүнд:

- АН-аас нэр дэвшсэн 10 нэр дэвшигч
- МАХН-аас нэр дэвшсэн 9 нэр дэвшигч

- 7 бие даан нэр дэвшигч

96 нэр дэвшигчдийн харилцах дансанд 210 иргэнээс нийт 85.0 сая төгрөгийн хандивын орлого төвлөрч, 22 нэр дэвшигчид иргэн болон хуулийн этгээдээс хандивын орлого төвлөрөөгүй байна.

Сумдын иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын ээлжит сонгуульд оролцсон 21 нэр дэвшигчдэд нэг сая төгрөгөөс дээш төгрөгийн хандивыг 33 иргэн өгч, 54.9 сая төгрөг төвлөрчээ.

Харин хуулийн этгээдээс хандивын орлого өгөөгүй байна.

Хавсралт 2 хуудас.

АЙМГИЙН АУДИТЫН ГАЗРЫН
ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР



Д.ЦОГБАДРАХ

Үндэсний аудитын газрын харьяа Орхон
аймгийн аудитын газрын 2017 оны 01 дүгээр
сарын 04-ний өдрийн 02 дугаар тоотын
хавсралт № 01

Нэг сая ба түүнээс дээш төгрөгийн хандив өгсөн иргэний жагсаалт

№	Хандивлагч иргэний эцэг /эх/-ийн нэр, өөрийн нэр	ДҮН
1	Т.Уянга	2,300,000
2	Т.Баяржаргал	2,900,000
3	Н.Бадамсүрэн	3,000,000
4	Д.Дулмаа	2,000,000
5	П.Түмэнжаргал	1,400,000
6	Ш.Хоролгарав	1,200,000
7	Ш.Баянцогт	1,000,000
8	Ч.Энх-Амгалан	1,000,000
9	Түмэндалай	2,000,000
10	Түмэндалай	1,000,000
11	Цэрэнчимэг	1,500,000
12	Цэрэнчимэг	1,000,000
13	Т.Буянжаргал	2,000,000
14	Г.Навчаа	1,000,000
15	О.Ганхуяг	1,500,000
16	Д.Пүрэвээ	2,000,000
17	Б.Ичинхорлоо	5,000,000
18	Ц.Энхтуяа	1,000,000
19	Ц.Энхбаатар	1,500,000
20	Х.Оюун-Эрдэнэ	1,000,000
21	Н.Содовжамц	1,000,000
22	С.Батбаяр	1,000,000
23	Г.Ариунболд	1,000,000
24	Б.Жаргалтуяа	3,000,000
25	Ё.Нарантуяа	1,650,000
26	Б.Ууганцэцэг	1,000,000
27	Л.Амарсанаа	1,000,000
28	Б.Ууганбаяр	2,000,000
29	Т.Солонго	1,500,000
30	Д.Дэлгэрдалай	1,500,000
31	А.Наранцэцэг	1,000,000
32	П.Жигжээ	1,500,000
33	Б.Ганзул	1,000,000
34	Б.Отгонбат	1,500,000
ДҮН		54,950,000

Үндэсний аудитын газрын харьяа Орхон
аймгийн аудитын газрын 2017 оны 01 дүгээр
сарын 04-ний өдрийн 02 дугаар тоотын
хавсралт № 02

**Сумдын ИТХ-ын сонгуульд оролцогч намуудад нэг сая ба түүнээс
дээш төгрөгийн хандив өгсөн иргэний жагсаалт**

№	Хандивлагч иргэний эцэг /эх/-ийн нэр, өөрийн нэр	Мөнгөн дүн
1	Дөлгөөн	2,000,000
2	С.Сувдаа	2,000,000
	ДҮН	4,000,000